



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ШИНЭ-ИДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/29

Эрдэнэт

Аудитын алба байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтын 4.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хууль, тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий дотоод аудитын албыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: С.Баянмөнх (Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Заяабаяр (Санхүү албаны дарга)

Д.Оюунмаа (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Н.Балжинням (Татварын байцаагч)

Л.Пүрэвжав (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

М.Долгормаа (Хүүхдийн цэцэрлэгийн багш)

Б.Нармөнх (Ерөнхий боловсролын сургуулийн Монгол хэлний

багш)

Д.Батцэцэг (Номын санч)

Д.Дашсүмбэрэл (Шинэ-Идэр Дулааны Эрдэнэт ХХК-ийн хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан)

Х.Золзаяа (Их эмч)

2.Ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцож сумын Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж байхыг аудитын алба (С.Баянмөнх)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулж 2020 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн А/09 дүгээр "Аудитын алба байгуулах тухай" захирамжийг хүчингүй болгосугай.

ДАРГА

М.БАТ-ЭРДЭНЭ

